



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2024/003/-НА-СТА-ОНӨҮГ

ЗААМАРЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70272248 Цахим хаяг: khatanbaatarga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмост сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

МНС. 03.21 № 01/2025
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР ХӨГЖИЛ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Д.ТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Заамар сумын Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Заамар сумын Заамар хөгжил ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байхад ажилчдад 25,040,0 мянган төгрөгийн цалин бодож цалин, ХХОАТ, НДШ-ийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Заамар хөгжил ОНӨААТҮГ-т тайлант онд сумын ИТХ-аас төсөв хуваарилаагүй, санхүүжилт болон өөрийн орлого байхгүй тул үйл ажиллагаа явуулаагүй, санхүүгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйн улмаас бусад байгууллагад өгөх өглөг хуримтлагдсан байна.

412507270

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь үйл ажиллагаа явуулаагүйн улмаас 2024 онд ажлын төлөвлөлт гүйцэтгэл хийгдээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	420,817.74	318,295.60
1.1	Эргэлтийн хөрөнгө	68,619.86	5,015.32
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	34,344.96	278.63
1.1.2	Дансны авлага	7,300.00	-
1.1.6	Бараа материал	26,974.90	4,736.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	352,197.88	313,280.28
1.2.1	Үндсэн хөрөнгө	352,197.88	313,280.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	420,817.74	318,295.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	420,817.74	318,295.60
2.1	ӨР ТӨЛБӨР	110,516.50	75,619.74
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	110,516.50	75,619.74
2.1.1.1	Дансны өглөг	28,194.24	-
2.1.1.2	Цалингийн өглөг	23,851.78	35,224.84
2.1.1.3	Татварын өр	11,063.70	15,187.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг	19,303.06	25,207.66
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	28,103.71	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	110,516.50	75,619.74
2.3	Эздийн өмч	310,301.24	242,675.87
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(77,140.53)	(144,765.90)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	420,817.74	318,295.60

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	88,238.18	25,548.83
2	Борлуулалтын өртөг	133,551.72	46,016.44
3	Нийт ашиг (алдагдал)	(45,313.55)	(20,467.61)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	39,616.92	39,857.76
17	Бусад ашиг (алдагдал)	-	7,300.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(84,930.46)	(60,325.37)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(84,930.46)	(67,625.37)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(84,930.46)	(67,625.37)
27	Орлогын нийт дүн	(84,930.46)	(67,625.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Мөрийн дугаа	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дү
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	125,165.70	-
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	125,165.70	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	106,675.83	10,502.75
	Ажиллагчдад төлсөн	39,665.99	9,222.80
	Бараа материал худалдан авахад төлсөн	44,650.71	-
	Ашиглалтын зардалд төлсөн	269.63	125.76
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	21,123.03	339.79
	Татварын байгууллагад төлсөн	760.26	-
	Бусад мөнгөн зарлага	206.20	814.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,489.88	(10,502.75)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,961.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,961.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйл	(6,961.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,796.08	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	22,796.08	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	23,563.58
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	23,563.58
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний д	22,796.08	(23,563.58)
4,1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	34,324.96	(34,066.33)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.00	34,344.96
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,344.96	278.63

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20.00	-	-	-	-	-	7,789.94	7,809.94
3	Залруулсан үлдэгдэл	20.00	-	-	-	-	-	7,789.94	7,809.94
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(84,930.46)	(84,930.46)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	387,421.77	-	-	-	-	-	-	387,421.77
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дү	-	-	-	-	-	-	-	-
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	387,441.77	-	-	-	-	-	(77,140.53)	310,301.24
11	Залруулсан үлдэгдэл	387,441.77	-	-	-	-	-	(77,140.53)	310,301.24
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(67,625.37)	(67,625.37)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дү	-	-	-	-	-	-	-	-
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	387,441.77	-	-	-	-	-	(144,765.90)	242,675.87

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹-ны залруулга гараагүй, 25,040.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25,040.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 24,047.3 мянган төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		мянган төгрөгөөр Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байхад ажилчдад цалин олгож цалин, ХХОАТ, НДШ-ийн өглөг үүсгэсэн байна.	1	25,040.0			1	25,040.0						
Тайлант онд ТУЗ-ийн хурлыг зохион байгуулаагүй, цаашдын зорилтод түвшин батлаагүй, үйл ажиллагаа явуулах эсэх тодорхойгүй	1	0					1	0				
Дүн	1	25,040.0			1	25,040.0	1					

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn